



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 09 сарын 12 өдөр

Дугаар А/527

Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5/a/, 29.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит IV хуралдааны 2 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 9 дүгээр сарыг “Оюунлаг Эрдэнэтчүүд” сарын аян болгон зарласантай холбогдуулан аяныг дэмжин ажиллах, номын сангийн фондыг нэмэгдүүлэх, нийгмийн салбарын танилцуулга ном хэвлүүлэхэд дэмжлэг үзүүлсүгэй.

2. Сарын аяныг зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр, хийх ажлын төлөвлөгөөг хоёрдугаар, зарцуулагдах төсвийн тооцоог гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Шаардагдах 20.000.000 /хорин сая / төгрөгийг Хөрөнгө оруулалтын зардлын жагсаалтын “Номын төв, сургууль, цэцэрлэг, соёл мэдээллийн төвүүдийн номын сангийн фондыг нэмэгдүүлэх” зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ